

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/34/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/429
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАВЗАНПАГМА
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ
19020407

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,580,375.00	5,176,675.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,580,375.00	5,176,675.00
354	Хангамжийн материал	8,580,375.00	5,176,675.00
35410	Бичиг хэргийн материал	134,000.00	134,000.00
35420	Аж ахуйн материал	3,406,875.00	3,406,875.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	153,300.00
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	3,039,500.00	1,482,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	101,031,975.21	78,723,563.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	101,031,975.21	78,723,563.89
392	Биет хөрөнгө	100,711,141.69	78,531,063.65
39203	Авто-тээврийн хэрэгсэл	198,000,000.00	198,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(103,208,333.48)	(132,375,000.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,694,860.00	41,414,760.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,408,549.96)	(31,606,778.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,112,230.00	11,112,230.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,479,064.87)	(8,014,147.91)
393	Биет бус хөрөнгө	320,833.52	192,500.24
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(449,166.48)	(577,499.76)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	109,612,350.21	83,900,238.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	109,612,350.21	83,900,238.89
51	Засгийн газрын хувь оролцоо	109,612,350.21	83,900,238.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,110,522.00	211,110,522.00
51101	Өмч: - төрийн	211,110,522.00	211,110,522.00
512	Хуримтлагдсан үр дүн	(106,561,251.79)	(132,273,363.11)
51210	Өмнөх үеийн үр дүн	(106,561,251.79)	(106,561,251.79)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(25,712,111.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,063,080.00	5,063,080.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	109,612,350.21	83,900,238.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,560,146,814.00	550,387,662.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,004,361.00	4,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,004,361.00	4,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,004,361.00	4,200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,004,361.00	4,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,558,142,453.00	546,187,662.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,179,059,153.00	152,478,062.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,399,153.00	9,925,646.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,161,660,000.00	142,552,416.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	379,083,300.00	393,709,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	379,083,300.00	393,709,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,588,732,109.78	576,099,773.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,588,732,109.78	576,099,773.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,865,054.99	425,462,627.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,898,464.60	165,609,791.42
210101	Үндсэн цалин	105,637,691.26	115,578,791.30
210102	Нэмэгдэл	30,894,407.26	38,005,326.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,956,955.08	7,724,104.40
210104	Урамшуулал	4,208,311.00	4,301,568.80
210105	Гэрээт ажлын хөлс	1,201,100.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,888,995.83	20,444,669.81
210201	Тэтгэврийн даатгал	11,780,199.06	14,368,455.93
210202	Тэтгэмжийн даатгал	1,527,199.31	1,596,470.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,221,799.82	967,506.74
210204	Ажилгүйдлийн даатгал	305,398.38	319,294.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,054,399.26	3,192,941.95
2104	Хангамж, бараа материалын зардал	14,117,979.64	14,842,800.00
210401	Бичиг хэрэг	2,297,650.00	1,253,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,663,350.00	12,703,669.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,979.64	885,931.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	220,000.00	2,883,800.00
210604	Урсгал засвар	220,000.00	2,883,800.00
2107	Томилолт, зочны зардал	301,000.00	6,692,800.00
210702	Дотоод албан томилолт	301,000.00	6,692,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,475,885.14	2,074,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,401,685.14	-

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,488,200.00	1,488,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,000.00	236,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,962,729.78	212,914,566.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,715,833.00	176,821,955.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,272,240.00	5,064,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,974,656.78	31,028,311.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,200,867,054.79	150,637,145.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,181,920,490.00	131,148,385.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,161,000,000.00	121,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,132,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,788,190.00	10,148,385.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,946,564.79	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,946,564.79	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	19,488,760.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,488,760.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(28,585,295.78)	(25,712,111.32)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	675,998.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	675,998.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(675,998.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(29,261,293.78)	(25,712,111.32)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,110,522.00	10,872,900.00	-83,109,778.01	138,873,643.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	5,809,820.00	5,809,820.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,110,522.00	10,872,900.00	-77,299,958.01	144,683,463.99
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-5,809,820.00	0	-5,809,820.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-29,261,293.78	-29,261,293.78
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,110,522.00	5,063,080.00	-106,561,251.79	109,612,350.21
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,110,522.00	5,063,080.00	-106,561,251.79	109,612,350.21
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,110,522.00	5,063,080.00	-106,561,251.79	109,612,350.21
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-25,712,111.32	-25,712,111.32
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	211,110,522.00	5,063,080.00	-132,273,363.11	83,900,238.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,558,142,453.00	546,187,662.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,558,142,453.00	546,187,662.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,179,059,153.00	152,478,062.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,399,153.00	9,925,646.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,161,660,000.00	142,552,416.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	379,083,300.00	393,709,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	379,083,300.00	393,709,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,558,142,453.00	546,187,662.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,558,142,453.00	546,187,662.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,523,398.21	395,852,516.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,697,364.60	165,300,121.34
210101	Үндсэн цалин	105,637,691.26	115,578,761.30
210102	Нэмэгдэл	30,894,407.26	38,005,356.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,956,955.08	7,414,434.32
210104	Урамшуулал	4,208,311.00	4,301,568.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,090,095.83	20,754,339.89
210201	Тэтгэврийн даатгал	12,981,299.06	14,368,455.93
210202	Тэтгэмжийн даатгал	1,527,199.31	1,596,470.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,221,799.82	1,277,176.82
210204	Ажилгүйдлийн даатгал	305,398.38	319,294.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,054,399.26	3,192,941.95
2104	Хангамж, бараа материалын зардал	15,325,479.64	12,842,800.00
210401	Бичиг хэрэг	2,215,150.00	1,253,200.00
210402	Тээвэр, шатахуун	11,953,350.00	10,703,669.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,979.64	885,931.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	220,000.00	3,037,100.00
210604	Урсгал засвар	220,000.00	3,037,100.00
2107	Томиллолт, зочны зардал	301,000.00	6,692,800.00
210702	Дотоод албан томиллолт	301,000.00	6,692,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,775,885.14	2,074,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,701,685.14	-

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,488,200.00	1,488,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,000.00	236,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,113,573.00	185,151,155.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,841,333.00	178,155,155.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,272,240.00	6,996,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,200,619,054.79	150,335,145.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,181,672,490.00	130,846,385.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,161,000,000.00	121,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,132,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,540,190.00	9,846,385.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,946,564.79	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,946,564.79	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	19,488,760.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,488,760.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,709,600.00	374,374,692.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,709,600.00	374,374,692.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,709,600.00	369,374,692.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,804,000.00	165,300,121.34
210101	Үндсэн цалин	126,120,000.00	115,578,761.30
210102	Нэмэгдэл	41,304,000.00	38,005,356.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,780,000.00	7,414,434.32
210104	Урамшуулал	3,600,000.00	4,301,568.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,408,500.00	20,754,339.89
210201	Тэтгэврийн даатгал	17,176,400.00	14,368,455.93
210202	Тэтгэмжийн даатгал	1,808,000.00	1,596,470.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,446,400.00	1,277,176.82
210204	Ажилгүйдлийн даатгал	361,600.00	319,294.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,616,100.00	3,192,941.95
2104	Хангамж, бараа материалын зардал	11,000,000.00	11,000,000.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,253,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,600,000.00	8,860,869.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	885,931.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,140,000.00	2,126,600.00
210604	Урсгал засвар	2,140,000.00	2,126,600.00
2107	Томилолт, зочны зардал	6,840,000.00	6,692,800.00
210702	Дотоод албан томилолт	6,840,000.00	6,692,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,074,200.00	2,074,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,488,200.00	1,488,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,000.00	236,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,442,900.00	161,426,631.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,446,900.00	154,430,631.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,996,000.00	6,996,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	5,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	374,374,692.23
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	374,374,692.23
132001	Орон нутгийн төсвөөс	-	374,374,692.23

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	152,324,209.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,324,209.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,477,824.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,842,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,842,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	910,500.00
210604	Урсгал засвар	910,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,724,524.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,724,524.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,846,385.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,846,385.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	121,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,846,385.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152,324,209.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	152,324,209.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	152,324,209.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Иргэдийн оролцоог хангаж олон нийтийн санаачилга, хамтын ажиллагааг дэмжих, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах төлөөлөх, нутаг дэвсгэрийн хэмжээнд сахилга дэг журмыг бэхжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, орон нутгийн байгалийн баялаг, газрыг зүй зохистой ашиглах хамгаалах орон нутгийн төсөв санхүү, өмчийн бодлого чиглэлийг тодорхойлж, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, төрийн бодлого шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангуулах, хяналт тавих нутаг дэвсгэрийн эдийн засаг нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох

бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд дотоод хяналт шалгалтын баг болон дотоод аудтын нэгж байхгүй байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 623,503.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,352.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,482.0 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 393,709.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 152,478.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 4,200.0 мянган төгрөг нийт 550,387.6 мянган төгрөг, өмнөх оноос 2,009,759.1 мянган

төгрөгөөр буюу 78 хувиар буурсан байна. Энэ нь цагаатгалын нөхөн олговор буурсантай холбоотой байна.

Зардал:

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 550,387.6 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 546,187.6 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 374,374.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140050001 тоот дансанд 2021 онд 393,709.6 мянган төгрөгийн орлого, 393,709.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140050401 тоот дансанд 152,478.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 152,478.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	8,580.3	5,176.6	-3,403.7
Үндсэн хөрөнгө	101,031.9	78,723.5	-22,308.4
Нийт хөрөнгө	109,612.3	83,900.2	-25,712.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	109,612.3	83,900.2	-25,712.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	109,612.3	83,900.2	-25,712.1

Бараа материалын дансны үлдэгдэл 5,176.6 мянган төгрөг болж 3,403.7 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 78,723.5 мянган төгрөг болж 22,308.4 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 4,519.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4,200.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 83,900.2 мянган төгрөг болж 25,712.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 353,878.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 353,878.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 39,831.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвөөс 393,709.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 393,709.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 393,709.6 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 393,709.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 374,374.7 мянган төгрөгийг зарцуулж, 19,334.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 374,374.7 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласан цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тайлант онд цагаатгах ажлын салбар комиссын урамшуулалд зарцуулах 5,398.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын захирамжаар цар тахлаас урьдчилан сэргийлэхэд зарцуулах 5,600.0 мянган төгрөг, цагаатгалын нөхөн олговорт олгох 121,000.0 мянган төгрөг, хамтарсан багийн сургалтад зарцуулах 9,900.0 мянган төгрөг, нэгдсэн үндэсний байгууллагаас сургалтад зориулж 10,580.0 мянган төгрөг, нийт 152,478.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,842.8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 910.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 23,724.5 мянган төгрөг, тэтгэмжийн зардалд 125,846.3 мянган төгрөг, нийт 152,324.2 мянган төгрөгийг зарцуулжээ. Орон нутгийн төсөвт 153.8 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд онцолсон асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд худалдан авсан 20,087.0 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг орлогод авч бүртгэлгүй тохируулах бичилтээр зардалд хааж, өөр бусад байгууллагад шилжүүлсэн байна. Энэ нь хүлээн авч байгаа байгууллага өөрийн хөрөнгө, бараа материалд бүртгэж авахгүй зарцуулах эрсдлийг бий болгож байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 156 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хуралдааны зардлын талаар дараагийн аудитаар анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52,454.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 550.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 51,904.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичив.

4.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 44,858.2 мянган төгрөгөөр дутуу, 7,046.5 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ГХУСЗардлаас "Согтуу жолоочтой хамтдаа тэмцье-1" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газарт өгөхөөр худалдан авсан 550.0 мянган төгрөгийн үнэ бүхий 500 ширхэг драггерийн хошууг бүртгэж авалгүй зарлагадсан ба Цагдаагийн газартай хүлээлцсэн акт байхгүй, цагдаагийн газар орлогод аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- Бусад байгууллагад шилжүүлэх эсэхээс үл хамааран худалдан авсан хөрөнгө, бараа материалыг орлогод авах, өөр бусад байгууллагад хүлээлгэж өгч байгаа тохиолдолд хүлээлцсэн акт үйлдэж, орлогод авхуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	52,454.8					1	51,904.8	1	550.0